



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.01 № 2/18 УАГ-САГ/2014/02-СТА-ТТЗ

Санхүүжилтийн үлдэгдлийг
төсөвт төвлөрүүлэх тухай

Гаалийн ерөнхий газрын 2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар тус газрын Төрийн сан дахь дансанд Монгол Улсын Гашуун сухайт дахь гаалийн газар, БНХАУ-ын Урдын дунд хошууны гаалийн газруудын хооронд "Хилийн хамтарсан шалгалт, ачааны манифест ижилсгэх" арга хэмжээг 2011 онд зохион байгуулсны зардалд АХБ-наас олгосон санхүүжилтийн 12,535,885.45 (Арван хоёр сая таван зуун гучин таван мянга найман зуун наян таван төгрөг 45 мөнгө) төгрөгийн үлдэгдэл байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.10-д... тусламжийн орлого нь төсвийн орлогын бүрэлдэхүүн хэсэг байна, 7 дугаар зүйлийн 7.7-д ... төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ыг үндэслэн ТОГТООХ НЬ:

3. Санхүүжилтийн үлдэгдэл 12,535,885.45 (Арван хоёр сая таван зуун гучин таван мянга найман зуун наян таван төгрөг 45 мөнгө) Төрийн сан банкин дахь Үндэсний аудитын газрын Төсвийн орлогын 900000601 тоот дансанд 2014 оны 4 дүгээр сарын 25-ны дотор төвлөрүүлэх,
4. Актын биелэлтийг 2014 оны 6 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Гаалийн ерөнхий газрын дарга О.Ганбат, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч Ч.Насанбат нарт хариуцуулав.

ТОГТООСОН:

УАГ-ын Санхүүгийн аудитын газрын

Ахлах аудитор

АКТЫГ

Ц.Гэрэл

ЗӨВШӨӨРСӨН:

Гаалийн ерөнхий газрын

СХОХ-ийн дарга, ерөнхий нягтлан

бодогч

Ч.Насанбат

УХА0122

УАГ0035